



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/09

Шивээговь сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/426 дугаар “Цэргийн бүртгэл явуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны цэргийн бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

А.Нандинцэцэг

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

3. Цэргийн бүртгэлийн ажлыг заасан хугацаанд чанартай зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь гаргахыг комиссын дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212-0024